



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/253

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх хэсэг, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Жаргалант сумын Бугат багийн Шинэ суурьшлын бүс, хаус хотхон 30 айлын амины орон сууцны зориулалттай “Бат дайчин” ХХК /4073886/-ийн эзэмшлийн 6000 метр квадрат газраас 73 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Цэвэгийн Нямсүрэн /ПД72123164/-д шилжүүлж, амины орон сууцны зориулалтаар, хаягийг Бат монгол 3 дугаар гудамжны 304 тоот болгон 15 жилийн хугацаагаар,

2. Жаргалант сумын Наран багийн 1 дүгээр гудамжны 1 тоотод байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай Тухын Дырдубай /ПЮ67123196/-ийн эзэмшлийн 500 метр квадрат газраас 50 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Аскерийн Жанарбек /БИ91121333/-д хаягийг Орчлон 1 дүгээр гудамжны 301 а тоот болгон худалдаа, үйлчилгээний зориулалтаар 15 жилийн хугацаагаар,

3. Жаргалант сумын Буянт багийн Цэцэрлэгт хүрээлэн 1 дүгээр гудамжны 142 тоотод байрлах амины орон сууцны зориулалттай Дүнхэрийн Чимэдцэрэн /ПЭ55112604/-ийн эзэмшлийн 962 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Хархүүгийн Мөнгөнтөгтох /ПЖ85010106/-д 13 жилийн хугацаагаар,

4. Жаргалант сумын Жаргалан баг Залуус 2 дугаар гудамжны 206 тоотод байрлах худалдаа үйлчилгээний зориулалттай Дарьсүрэнгийн Яйчил /ПЮ61010271/-ын эзэмшлийн 375 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Яйчилийн Ганболд /ПЮ83021879/-д 15 жилийн хугацаагаар,

5. Жаргалант сумын Цамбагарав баг 7 дугаар гудамжны 25 тоотод байрлах худалдаа, үйлчилгээний зориулалттай Цэнд-Аюушийн Сайнбаяр /ПЭ87071403/-ын эзэмшлийн 68 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Мөнхбатын Нямсүрэн /ПЖ91011905/-д хаягийг Заны 3 дугаар гудамжны 309 а тоот болгон 11 жилийн хугацаагаар,

6. Жаргалант сумын Бугат баг Батмонгол 2 дугаар гудамжны 200 тоотод байрлах амины орон сууцны зориулалттай Тулгаагийн Анхбаяр /ПЭ89032426/-ын эзэмшлийн 90 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Бөх-Амгалангийн Төртогтох /ПЮ92021313/-д 14 жилийн хугацаагаар тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

7. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлэн авч, газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлэхийг дээрх иргэдэд үүрэг болгосугай.

8. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэнтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ